



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/969

Өлгий

Өсвөр үеийн шигшээ баг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тамирчдын өрсөлдөх ур чадварыг нэмэгдүүлэх, Тив, дэлхий, олон улс, улсын чанартай уралдаан тэмцээнд амжилт гаргах спортыг дэмжих зорилгоор аймгийн Засаг даргын дэргэд өсвөр үеийн шигшээ багийг чөлөөт бөх, сагсан бөмбөг, хөл бөмбөг, бокс, волейбол, хүндийн өргөлт, жүдо, таеквондогийн төрлөөр байгуулан 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн хичээллүүлсүгэй.

2.Өсвөр үеийн шигшээ багийн дасгалжуулагч нарыг сонгон шалгаруулах журмыг боловсруулж бэлтгэл ажлыг ханган ажиллахыг Биеийн тамир спортын газар /Х.Хайнар/-т даалгасугай.

3.Шигшээ багийн дасгалжуулагч нарын цалин хөлс, бусад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж байхыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Т.Фестиваль/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАУЫРЖАН